



102

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 9/01

Урт

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017-2020 оны үзэл баримтлалын
хэрэгжилтийн явцын тухай

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20,5 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017-2020 онд баримтлах үзэл баримтлалын хэрэгжилтийг 80,4 хувь буюу хангалттай хэрэгжиж байна гэж үзсүгэй.

2. Үзэл баримтлалын хэрэгжилтийг эрхийн хугацаанд бүрэн хангаж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

461190004



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 10 сарын 21-ний өдрийн 21 дугаар
тогтоолын хавсралт

ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН

2017-2020 ОНД БАРИМТЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТ

Сумын ИТХ-ын эрхэм зорилго:

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлэн бэхжүүлэх, Хөдөө аж ахуй, Уул уурхай болон бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан сумын эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг иргэдийн идэвхтэй оролцоонд түшиглэн орон нутгийн нөөц боломжоо дайчлан шийдвэрлэж, төрийн болон иргэний нийгмийн байгууллага, баялаг бүтээгчдийн хамтын оролцоотойгоор орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах явдал юм.

№	Заалт	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1.1.	Боловсролын салбарыг нийгмийн хөгжлийн тэргүүлэх салбар гэж үзэж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, монгол ёс заншлаа дээдлэх, эх хэлээ төгс эзэмших, эх оронч, итгэл даах чадвартай, боловсролтой, хүрээлэн буй орчноо хамгаалах хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэхэд анхаарах	Хүүхэд нэг бүрийг хөгжүүлж монгол ёс заншлаа дээдэлсэн эх оронч иргэн болох зорилгоор Хүүхэд хөгжлийн түлхүүр, Сайхан бичигтэй Өмнөговь, Оюуны хурд, Англи хэлтэй Өмнөговь зэрэг хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн багш бүр нэг дугуйлан уриан дор нийт сурагчдын 80% нь хамрагдаж олон төрлийн арга хэмжээнүүдийг сурагчид, эцэг эхчүүдийн дунд амжилттай зохион байгуулж байна.	70
		“Монголын алт-МАК” ХХК-ний санаачлагаар “Эко сургууль” төслийг сумын ЕБС дээр хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ төслийн хүрээнд багш, эцэг эх, сурагчдад 2 удаа сургалт зохион байгуулж сургуулийн орчныг эрүүл аюулгүй байлгах чиглэлээр анхааран ажиллаж байна.	

<p>1.2.</p>	<p>Боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын чанарыг сайжруулах, багш нарын ур чадварыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчинг бүрдүүлэх</p>	<p>Өмнөговь аймгийн "Буянт" зуслан болон Тост багийн төвд байрлах Ирвэс хамгаалах сангийн Эко зусланд ЕБС-ийн сурагчдыг жил бүр хамруулан байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг мэдээлэл олгож ирсэн.</p> <p>Сургалтын чанарыг сайжруулж багш нарын харилцаа хандлага, арга зүйг дээшлүүлэх зорилгоор Багш хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлж багшийн ажлын байран дээрх хөгжилд Сайн хичээл туршлага, урилгат хичээл, хамтын хичээлд 100%, орон нутгийн болон төвлөрсөн сургалтанд 85% хамрагдаж дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр математик, англи хэлний сургалт 5-10%-аар ахисан үзүүлэлттэй байна. Мөн дутагдалтай 4 багшийг хөрвөх сургалтанд хамруулан математик, бага ангийн багшаар мэргэшүүлэн сургаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг жирийн ангид суралцуулан сурах орчин бүрдүүлсэн.</p> <p>Гадаад хэлний сургалтын чанарыг сайжруулах зорилгоор ЕБС-ийн гадаад хэлний 2 багшийг "Зегийн үүр" хөтөлбөрийн хүрээнд Филлипин улсад мэргэшүүлэх сургалтанд хамруулсан.</p> <p>Канад улсаас сайн дурын 2 ажилтан ирж ЕБС-ийн сурагчдад вакумжуулсан 14 хоногийн сургалтыг зохион байгуулсан.</p>	<p>90</p>
<p>1.3.</p>	<p>Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах, эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, нийтийн биеийн тамир спортыг дэмжих, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг бууруулах, эмч эмнэлэгийн ажилтны чадамж, харилцаа, хандлага, удирдлагын тогтолцоог сайжруулах</p>	<p>Эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг "Өсөх зоос" ХХК-ний 583,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулан, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 473,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. Мөн "АГМ майнинг" ХХК-ний дэмжлэгтэйгээр иргэдийг жил бүр үнэ төлбөргүй үзлэг оношлогоонд хамруулж ирсэн. Мөн Альшаа аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн БОЭТ, УИХ-ын гишүүний дэмжлэгтэй үнэ төлбөргүй үзлэгийг зохион байгуулсан. Эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор орон нутгийн 11,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 барилгыг хүүзүүвч хийж холбосон.</p> <p>Эрүүл мэндийн төвийн 2 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж Өмнөговь аймгийн Төрийн албан хаагчийн орон сууцны дэмжлэгт хамруулсан.</p> <p>Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад анхаарч сумын эрүүл мэндийн төвийг мобайл технологит холбосноор үзлэгийн мэдээллийг Улаанбаатар хотын Эх</p>	<p>90</p>

		<p>нялхасын үндэсний төвд шууд мэдээлэгдэж ургийн гажиг, өсөлтийг шууд хянах боломжтой болсон.</p> <p>Сум орон нутагт ирж ажиллаж байгаа их эмч нарт жил бүр 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлдэг бөгөөд 1 сувиллагчийн сургалтын төлбөрийг шийдвэрлэсэн.</p> <p>Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Насанжаргалын санаачлагаар ЕБС-д эрүүл мэндийн кабинетийг тохижуулж эмчтэй болгосон. Мөн тус кабинетэд НҮБ-аас тохижилт хийхээр хөрөнгө шийдэгдсэн.</p> <p>Залуучуудын спортын их наадмыг жил бүр сумандаа зохион байгуулж, аймагт зохион байгуулагдсан урлаг, спортын наадамд 2 удаа оролцуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.</p> <p>Орон нутгийн 35.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Хөв" хороололд хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулж, төв цэцэрлэгт хүрээлэнг "Бласт" ХХК-тай хамтран 100.0 сая төгрөгөөр тохижилт хийж хүүхэд залуучууд, ахмад настан, иргэдийг чөлөөт цагаа зөв боловсон, эрүүл аюулгүй орчинд өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.</p>	70
1.4.	<p>Сумынхаа үнэт зүйлс, бахархалыг тодорхойлон, говийн онцлог давтагдашгүй өв соёлыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, алдар гавьяат түүхэн хүмүүсээ алдаршуулах ажлыг зохион байгуулах, хүүхэд, залуучууд эх орон, хил хязгаарын үнэ цэнэ, нутаг орноороо бахархах үзлийг бий болгож төлөвшүүлэх</p>	<p>Сумаас төрөн гарсан Монгол улсын начин Д.Төмөрбаатар агсны нэрэмжит барилдааныг жил бүр зохион байгуулж начны хөшөөг "Хөгшөө" ОНӨААТҮГ-ын 25 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийлгэж ЕБС-ийн өмнөх талбайд байрлуулсан.</p> <p>Гоёот багийн иргэн уран дархан Д.Базар агсны бүтээлийн үзэсгэлэнг гаргаж иргэд, сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдэд үзүүлж сурталчилсан.</p> <p>ЕБС-ийн 9-р ангийн сурагчид болон дотуур байрны хүүхдүүдийг Хилийн баганатай танилцуулж Хилийн цэргийн ангийн офицероор эх орны хил хязгаар, халдашгүй дархан байдлын талаар яриа таниулга хийлгэсэн.</p>	90
1.5.	<p>Ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хангамжийг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрх гэрийн хөгжил, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих, ажилтай иргэн, орлоготой өрхийн тоог нэмэгдүүлэх</p>	<p>"RDC" ХХК-ий хөрөнгө оруулалтаар зорилтот бүлгийн 5 өрхөд гэр, хашаа барьж өгч амьдрах нөхцлийг сайжруулсан. Өсөх зоос, Сауд гоби Коэл транс, Саус гоби сэндс ХХК-ууд 5 өрхөд гэр олгосон. Сум орон нутгаас өрх тус бүрт газрын асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлсэн. Бласт ХХК-д хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэнийг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин тогтмол цалинжуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас залуу малчдыг дэмжих зорилгоор 10 өрхөд 31 сая төгрөгөөр малжуулсан. 2 ахмад настан зөвлөх үйлчилгээнд</p>	

		<p>хамрагдаж хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилтээ авсан. Мөн ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 6 ахмад настанд буцалтгүй тусламжийн санхүүжилт олгосон. Өрх толгойлсон эцэг, эхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 5 иргэнд 4,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 7 иргэнд 6,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 35-аас дээш насны ажил олоход хүндрэлтэй 4 иргэнд 15 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Сумын нийт ахмадын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 304 ахмад настан оролцсон. Арга хэмжээнд "Миний ардын сэтгэл цагаан" тоглолтыг бүрэн эхээр нь тоглуулж баярын хурал, хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээг зохион байгуулж УИХ-ын гишүүний болон орон нутгийн зүгээс гарын бэлэг гардуулсан. Мөн ахмадын өргөөний дээврийн засвар 6.7 сая төгрөгөөр засварлаж, 10 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>УИХ-ын гишүүн Н.Амарзаяагийн урилгаар 23 ахмадыг төрийн ордонг танилцуулж "Дуулах өдөр" ахмадын нэгдсэн арга хэмжээнд оролцуулсан.</p>	
<p>Хоёр. Бүс нутгийн хөгжлийн чиг хандлагад тулгуурлан сумын эдийн засаг, хөрөнгө оруулалтыг оновчтой шийдвэрлэх, тогтвортой хөгжлийг хангах, дэд бүтцийг сайжруулах, уул уурхайн төслүүдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглүүлэх, орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилтыг шийдвэрлэх</p>	<p>2.1. Эдийн засгийн хөгжилд хариуцлагатай уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлэх, уул уурхайн томоохон төслүүдийг тогтвортой ажлын байр бий болгох, малчдыг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлэх</p>	<p>"Өсөх зоос" ХХК орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн засмал зам дагуух ногоон байгууламжийг шинээр хийж 2 хүнийг ажлын байраар хангасан. Мөн 4 улирлын хүлэмжийг барьж ашиглалтанд оруулан 2 хүнийг ажлын байраар хангасан.</p> <p>Сум хөгжүүлэх сангаас 26 иргэн аж ахуйн нэгжид зээл олгож 25 ажлын байрыг шинээр бий болгож, нийт 44 иргэнийг ажлын байраар хангасан байна.</p> <p>"Говь зулганай" ХХК нь уул уурхайн компаниудтай ажлын хувцас нийлүүлэх гэрээ байгуулан 6 хүнийг ажлын байраар хангасан байна.</p> <p>Малжуулах төслийг 2017 оноос хойш цөөн малтай 29 өрх малжуулсан. Төсөлд шинээр 32,0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.</p>	70
<p>2.2.</p>	<p>Орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны</p>	<p>Улс, аймаг, орон нутгийн төсвийн 6,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээр хийгдэж</p>	90

<p>2.3.</p>	<p>Гүйцэтгэлийг сайжруулахад хяналт тавьж, төсвийн сахилга батыг дээшлүүлэх</p> <p>Орон нутгийн чанартай автозамыг нэмэгдүүлэх, арчлан хамгаалах, цэвэр бохир ус, цахилгаан, дулааны шугам сүлжээг нэмэгдүүлэх, иргэдийг орон сууцжуулах төсөл хөтөлбөрийг дэмжиж бага дунд орлоготой иргэдийг хамруулах, амьдрах орчинг сайжруулах</p>	<p>байгаа хөрөнгө оруулалтуудад ИТХ-ын Хяналтын зөвлөл болон ЗДТГ-аас томилогдсон ажлын хэсгүүд тухай бүрт хяналт тавьж ирсэн.</p> <p>Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар цэвэр, бохир ус, дулааны шугамын өргөтгөлд 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.</p> <p>Цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг тогтворжуулах зорилгоор Монгол улсын Засгийн газрын 500,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дэд станцыг барьж ашиглалтанд оруулсан.</p> <p>Сумын төвийн хатуу хучилттай автозамыг нэмэгдүүлэх зорилгоор 2 км авто замын зураг төсвийг хийлгэсэн.</p> <p>Орлогод нийцсэн орон сууц хөтөлбөрийн хүрээнд 16 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Мөн "Саус гоби сэндс" ХХК-ний хөрөнгө оруулалтаар 48 айлын орон сууцны барилгыг эхлүүлсэн.</p>	<p>90</p>
<p>2.4.</p>	<p>Говь нутгийн байгалийн дахин давамгайлалгүй унаган төрх, усны нөөц, ургамалыг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хүн амын ундны усны чанарыг сайжруулах</p>	<p>Тус сумын Тост багийн нутаг дахь байгалийн өвөрмөц хэв шинж, ховор амьтан, ургамал бүхий Тост Тосон бумбын нурууг улсын тусгай хамгаалалтанд авах ажлыг 2010 оноос эхлэн орон нутгийн удирдлага, иргэд, ТББ-ууд хамтран холбогдох арга хэмжээг удаа дараа авч хэрэгжүүлсний хүчинд 2017 оны 03-р арын 15-ний өдрийн МУ-ын Засгийн газрын 91-р тогтоолоор 743058 га-аар УТХГН-т хамруулсан. Харин 2019 оны 08-р сарын 14-ний Засгийн газрын хуралдаанаар Тост Тосон бумбын нурууны хилийн заагийн шинэчлэн баталж 896540,37 га болгон нэмэгдүүлсэн. Ингэснээр Хөвд, хуршуут орчмын 22 булаг шанд бүхий баян бүрдүүд бүрэн хамгаалалтанд орсон байна. Мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 88 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор сумын хэмжээнд мод тарих өдрийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн. 2019 онд шинээр 2,2 га талбайд 6819ш мод, 2018 онд 3,8 га-д 17000 ш мод, 2017 онд 4000ш мод тус тус таригдсан байна. 2019 оны хагас жилийн байдлаар Бүх нийтээр мод тарих аяны хүрээнд нийтийн эзэмшлийн талбай болон албан байгууллагууд гаднах орчиндоо ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг дор бүрнээ чанартай зохион байгуулж 28 аж ахуйн нэгж, 36 өрх, 926 иргэн хамрагдан ажилласан.</p>	<p>70</p>

<p>2.5.</p>	<p>Уул уурхайн нөлөөллөөс үүсч буй тоосжилт, байгаль экологи, хүн амын эрүүл мэндэд хор нөлөөгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэх, иргэддээ экологийн боловсрол олгох</p>	<p>Экологийн боловсролыг олон нийтэд таниулах, олгох ажлыг жил зохион байгуулж ирсэн. Энэ жилийн хувьд дэлхийн нийтээр усны өдрийг "Цэнгэг Ус-Тэгш Хүртэмж" уриан дор Өмнөговь аймгийн баруун бүсийн сумдыг хамруулсан "Дэвжээ" тэмцээнийг суманд дөрөвдүгээр сарын 6-ний өдөр зохион байгууллаа. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан "Ус бохирдуулагчийн төлбөрийн тухай хууль"-ийг сурталчлан таниулах, говийн хамгийн үнэт баялаг болох усны нөөцийн ашиглалт хамгаалалт, усны нөөцийг нэмэгдүүлэх, иргэдэд мэдээлэл олгох үүднээс тус тэмцээнийг зохион байгуулсан юм. Тэмцээнд төрийн албан хаагч, ус ашиглагчийн төлөөлөл, бизнес эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн сурагч, төрийн бус байгууллага зэрэг тал бүрийн төлөөллүүдийг оролцуулан нэг баг 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Оролцогчид ус бохирдуулагчийн төлбөрийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, саад бэрхшээл, даван туулах арга зам, усны нөөцийн зохистой хэрэглээ, усыг хэмнэлттэй ашиглахын ач холбогдол зэргийг урлаг уран сайхны чөлөөт сонголтоор илэрхийлэн өрсөлдсөн. Мөн Жил бүрийн гуравдугаар сарын 3-ны өдрийг байгалийн амьтан, ургамлыг хамгаалах өдөр болгон дэлхийн олон улс орон тэмдэглэн өнгөрүүлсээр ирсэн байдаг. 2019 онд дээрх тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан Гурвантэс сумын ЭДТГ, ЕБС-аас санаачилсан "ЭД ЗҮЙЛСЭД ХОЁР ДАХЬ АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ" уралдааныг уул уурхайн салбарын компаниудын зүгээс хамтран зохион байгуулж оролцсон. Энэхүү уралдааны зорилго нь ЕБС-ийн сурагчид болон эцэг, эхчүүдэд байгаль орчныг хамгаалах, байгаль орчны үнэ цэнийг танин мэдэх, хайрлах хүсэл тэмүүллийг төлөвшүүлэх, тогтвортой хөгжлийн боловсролын бодлогыг танилцуулан хог хаягдлын талаарх мэдлэгийг сайжруулж, эд зүйлсийг дахин боловсруулан ашиглах бүтээлч арга туршлагаас суралцан багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилготой зохион байгуулагдсан. Гурвантэс суманд үйл ажиллагаа явуулж буй "МАК"ХХК, "ЧИНХУА-МАК"ХХК, "БЛАСТ" ХХК, "БААТАРВАН ТРАНС" ХХКомпаниуд хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 1-12 дугаар ангийн 18 анги хамт олон, 270 гаруй эцэг эхчүүд оролцсон байна.</p>	<p>70</p>
<p>2.6.</p>	<p>Сумын төвийн эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх, дулаан хангамж, харилцаа холбоо мэдээллийн хүртээмжийг сайжруулж, үнийн уян хатан бодлогыг баримтлах</p>	<p>Цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг тогтворжуулах зорилгоор Монгол улсын Засгийн газрын 500,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дэд станцыг барьж ашиглалтанд оруулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 147,2 сая төгрөгийн хөрөнгөөр Шугшаа хорооллын цахилгаан дамжуулах агаарын шугамыг</p>	<p>90</p>

	<p>шинэчилсэн. Орон нутгийн 5.5 сая төгрөгийн хөрөнгөөр цэнгэлдэх хүрээлэнг байнгын эрчим хүчин холбосон</p> <p>Аймгийн төсвийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэ уурын зуух барьж ашиглалтанд оруулсан. Мөн 3 км дулааны шугам сүлжээний өргөтгөл хийсэн байна.</p> <p>Аймгийн төсвийн 100,0 сая төгрөгөөр Тост багт Юнителийн сүлжээний тоног төхөөрөмжийг шинээр суурилуулсан.</p> <p>"Бласт" ХХК-ний 25 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар мэдээлэл, лавлагааны "Хур" системийг сумандаа нэвтрүүлсэн.</p>	
<p>2.7.</p>	<p>Говийн булаг шанд гүний усыг ашиглан усалгаатай газар тариалан эрхэлж хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуйг дэмжих, малын тоог чанарт шилжүүлэх, мал сүргийг эрсдэлээс хамгаалах, малчны хөдөлмөрийг хөнгөвчлөх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх</p>	<p>90</p> <p>Хуруутын услалтын систем болон уст цэг ашиглаж 2017 оноос хойш 30-50 өрх газар тариалан эрхэлж байна. 15 хүлэмжинд хүнсний ногоо тариалсан. Сүүлийн 3 жилд хүлэмжийн тоог 3-р нэмэгдүүлсэн</p> <p>2019 онд "Өсөх зоос" ХХК 4 улирлын хүлэмж барьж суманд хүлээлгэн өгсөн.</p> <p>2019 онд Бага овоо, Гоёт багт ОНХС-ийн хөрөнгөөр тэжээлийн ургамал тариалах талбайг хашаажуулсан.</p> <p>Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөхөөр хонь тэмээ ноослох цахилгаан хайчийг гэрээгээр ашиглуулж жилд 200-300 тэмээ ноослож байгаа.</p> <p>2019 оны Хүнс хөдөө аж ахуй үйлдвэржилтийн жил болгон зарласантай холбогдуулан 21,0 сая төгрөгөөр арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг худалдан авч малчдын бүлэгт хүлээлгэн өгсөн.</p>
<p>2.8.</p>	<p>Нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бодлогыг тодорхойлоход эрдэмтэн, шинжээчид, нутгийн иргэд, ахмадууд, мэргэжилтнүүдийн саналыг тусгах, хөрш зэргэлдээ гадаад улс орнуудын эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуй, байгаль орчны чиглэлээр туршлага судалж хэрэгжүүлэх</p>	<p>70</p> <p>Хүлэмжийн аж ахуй эрхлэх чиглэлээр Урт багийн иргэн О.Дэлгэрмаа БНСУ-д туршлага судлуулсан. Мөн Я.Цэцэгмаа, О.Үнэн-өгүүлэгч, С.Замбага нарыг ӨМӨЗО-ны Баянуур аймгийн туршлага судлах арга хэмжээнд хамруулсан. Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нөхөрлөлийн төлөөлөл Хэнтий, Дорнод, Баянхонгор, Өвөрхангай аймгуудаар явж туршлага судалсан.</p> <p>Хөрш зэргэлдээ БНХАУ-ын Алышаа аймгийн Эзнээ хошуутай хамтран ажиллах гэрээг байгуулсан.</p>

2.9.	Суманд аялал жуулчлалын сүлжээг өргөжүүлэх, байгалийн үзэсгэлэнт, түүхэн дурсгалт газруудыг хамгаалах, дэд бүтцийг сайжруулах, жуулчдын ая тухтай аялах нөхцлийг бүрдүүлэх, жуулчдыг татах гадаад дотоодын хөтөлбөр төслүүдийг дэмжих	Тус суманд "Батаарын өлгий" жуулчны бааз тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд жилээс жилд ирэх жуулчдын тоо нэмэгдэж байна. Жуулчны бааз нь жуулчдын ая тухтай аялах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өргөтгөл хийж үйлчилгээгээ сайжруулсан. Мөн Хонгорын гол-хэрмэн цавын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөний хэлэлцүүлгийг суманд зохион байгуулж иргэд, төлөөлөгчдөөс гарсан саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.	30
2.10.	Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, ашиглалт, худалдан авалтанд байнгын хяналт тавих	Сумын өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд жил бүр хяналт тавьж актлан устгах шаардлагатай хөрөнгийг байгууллагууд дээр нь очиж үзэн, зөвлөлийн хурлаараа хэлэлцэн сумын ИТХ-д уламжлан шийдвэрлүүлж, актлан устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн байгууллагуудын өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө, тайланг жил бүр авч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын талаар зөвлөгөө өгдөг. 2017-2019 оны хооронд төрийн байгууллагуудад 8309,3 сая төгрөгийн хөрөнгийг шинээр бүртгэн авч, шаардлага хангахаа больсон эвдэрсэн, ашиглалтын хугацаа дууссан, дахин ашиглах боломжгүй болсон 3114,6 сая төгрөгийн хөрөнгийг сум, аймгийн ИТХ-аар актуулан дуудлага худалдаагаар худалдах, устгах ажлыг зохион байгуулсан байна.	90
Гурав. ИТХ-ын байгууллагын бие даасан байдал, үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хамтын үйл ажиллагаа, төрийн ухаалаг үйлчилгээ, ил тод байдлыг сайжруулах, иргэдийг мэдээллээр хангах боломжийг нэмэгдүүлнэ.			
3.1.	Хурлын байгууллагын бие даасан байнгын ажиллагаа, эрх зүйн чадамж, бааз суурийг бэхжүүлэх, боловсон хүчнийг мэргэжлүүлэх, төлөөлөгчдийг чадавхижуулах, сургах, бусад аймаг, сумдуудын туршлагаас суралцах боломжийг судлан хэрэгжүүлэх	Сумын ИТХ-ын төлөөлөгчдийг аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулагдсан 3 удаагийн сургалтанд хамруулсан. Мөн Нутгийн удирдлагын холбоотой хамтарч төлөөлөгчдийн сургалтыг зохион байгуулсан. Нутгийн удирдлагын шинэ ордонтой болсонтой холбогдуулан Орон нутгийн хөгжлийн сангийн 49,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хуралдааны танхим болон албан ерөөнүүдийг тохижуулсан. Сумын ИТХ нь 2017, 2018 оны ажлаараа аймагтаа дэд байр эзэлсэн.	90
3.2.	Хурлын байгууллагын байнгын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор автомашинтай болох	ЗДТГ-ын ашиглаж байсан Ланд-105 автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж байна.	100

3.3.	Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж, иргэдийн өргөдөл гомдол, саналыг хүлээн авч эргэх холбоотой байх, ТББ, сүм хийдүүдтэй хуулийн хүрээнд идэвхтэй харилцах зэрэг шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	ИТХ-ын ажилтантай болж хурлын танхимд хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан, мэдээллийн хэрэгсэл ашиглан иргэдэд мэдээллийг түгээн ажиллаж байна. Мөн "Өглөөний цай" уулзалтыг зорилтот бүлгүүдтэй хийж иргэдээс санал хүсэлтийг авч шийдвэрлэж ирсэн. Өмнөговь аймгийн Маанийн хийдтэй хамтран нутаг ус аргадах, ард иргэдийн сайн сайхныг даатгаж 2 удаа нэгдсэн байдлаар ном хуруулсан.	90
3.4.	Иргэдэд шаардлагатай хууль тогтоомж болон бусад хурлын шийдвэрийг тайлбарлан таниулж сурталчлах	"Иргэн ба хууль" хууль сурталчлах сарын аяныг жил бүр зохион байгуулж иргэдэд эрх зүйн мэдлэг түгээж ирсэн. Мөн албан байууллагуудад эрх зүйн хөтөчийг томилон хууль сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Багуудын хурлаар хууль тогтоомж болон хурлаас гарсан шийдвэрүүдийг сурталчлан ажилладаг. ИТХ-ын тэргүүлэгчдээс баталсан тогтоолууд болон хуралдааны тогтоол, ажлын тайлангаар гарын авлага бэлтгэж төлөөлөгчдөөр дамжуулан иргэдэд сурталчилсан.	90
3.5.	Сумын ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнг сумын ЗДТГ, албан байгууллагууд эргэн мэдээлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын уялдааг сайжруулах	2007 оноос хойш ИТХ-ын Тэргүүлэгчид болон Хуралдааны тогтоолуудыг хяналтад авч холбогдох мэргэжилтнүүдээс хэрэгжилтийг тооцуулан ажиллаж байна.	90
3.6.	Багийн иргэдийн нийтийн хурлыг чадваржуулах, тулгамдсан асуудлаа иргэд өөрсдөө шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх, мэдээлэл хүргэх, мэдээллийн сүлжээг өргөжүүлэх	Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарыг чадавхжуулах зорилгоор аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулсан сургалтанд 2 удаа хамруулсан. 5 багийн нутаг дэвсгэрийг үүрэн телефоны сүлжээнд холбосноор мэдээллийг түргэн шуурхай түгээх нөхцөл бүрдсэн.	90
3.7.	Төрийн албаны ажилтнуудын мэргэжил үр чадварыг дээшлүүлэх, хариуцлагатай, ёс зүйтэй ажиллах, төрийн албыг хүнд сурталгүй байлгаж, авлигатай тэмцэхэд хурлын ажлыг чиглүүлэн, хяналтын чиг үүргийг сайжруулах, иргэдэд нээлттэй ил тод байх, иргэн төвтэй төрийн үйлчилгээг дээдлэх бодлого баримтлах	Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор нэг цэгийн үйлчилгээний заалыг тохижуулж нэг дороос төрийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн. Мөн мэдээлэл лавлагааны "Хур" системийг нэвтрүүлснээр иргэд нэг дороос 10 төрлийн лавлагаа авах боломжийг бүрдүүлсэн. Нээлттэй хаалганы өдрийг жил бүр 2-оос доошгүй удаа зохион байгуулж ирсэн. Хилийн цэргийн анги, заставууд болон багуудаар явж мэдээлэл хүргэж ирсэн. Иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжтэй болгох зорилгоор шинээр Бага-Овоо багийг байгуулж багийн төвийг барилгыг 150,0 сая төгрөгөөр барьж байгуулан ашиглалтанд оруулахад бэлэн болсон.	90

111

3.8.	Хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж идэвхтэй ажиллуулах	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг хил гааль, уул уурхайн төлөөллийг оролцуулан бүрэлдэхүүнийг өргөтгөн үйл ажиллагааг явуулж ирсэн. Зөвлөлийг өргөтгөснөөр үйл ажиллагаа тогтмолжиж тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг шийдэх боломж бүрдсэн. Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ЗДТГ-ын төсөвт жил бүр торгуулийн орлогын 40 хувийн хөрөнгийг тусган гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулж ирсэн.	90
3.9.	Иргэдийн төлөөллийн байгууллагын хувьд Төлөөлөгчдийг сонгогдсон тойрогтоо ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хурлын үйл ажиллагааг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, иргэдийн оролцоо, дуу хоолойг сонсож хурлын нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх	Төлөөлөгчдийн сонгогдсон тойргийнхоо сонгогчидтой уулзаж, тойрогтоо ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор шатахууны дэмжлэг үзүүлж ирсэн. Мөн хаврын айл хэсэлт болон, хагас бүтэн жилийн мал тооллогоор өрхүүдээр явж иргэдийн санал хүсэлтийг сонсож ирсэн. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулж байгаа ажлуудыг мэдээллийн хэрэгслээр сурталчилж ирсэн.	70
3.10.	Иргэдийн амгалан тайван ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил, хар тамхи мансууруулах бодис, архи дан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хууль хяналт, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах	Иргэдийн амгалан тайван ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тэмдэглэлт баяр ёслолуудын үеэр Цагдаагийн тасагтай хамтран Уриалга гарган олон нийтийн эргүүлийг томилон ажиллуулж ирсэн. Архигүй Монгол хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотоос сургагч багш, урьж ирүүлэн иргэд болон албан байгууллагуудад сургалт зохион байгуулсан. Мөн Өмнөговь аймгийн Цагдаагийн газар болон сумын Цагдаагийн тасгаас иргэдэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж ирсэн. Жил бүр "Иргэн ба хууль" хууль сурталчлах арга хэмжээний хүрээнд сурталчилгааны ажлуудыг зохион байгуулсан.	70
Хэрэгжилтийн дундаж хувь			80,4



113

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 9/аа

Урт

**2018 оны орон нутгийн төсвийн шилжих
үлдэгдлээс санхүүжүүлэх зардлын
жагсаалт батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 б, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл 57.3 заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Ерөнхий дансны 2018 оны жилийн эцсийн үлдэгдэлийг 50496.5 мянган төгрөгөөр баталсугай.

2. 2019 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид дор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай


		/мян.төг/
2.1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9212.3
2.1.1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	7212.3
2.1.2	ИТХ-ын даргын нөөц хөрөнгө	2000.0
2.2	Засаг дарга	41284.2
2.2.1	Урсгал зардлын дээд хэмжээ	41284.2
2.2.1.1	Засаг даргын тамгын газар	35854.2
2.2.1.2	Засаг даргын нөөц хөрөнгө	5430.0
Дүн		50496.5

3. Орон нутгийн 2019 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 3 837 573.4 мянган төгрөгөөр баталсугай.

4. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийг баримтлан орон нутгийн төсвийн тэнцлийг бүрэн хангаж, хэрэгжилтийг зохион байгуулан, зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг сумын засаг дарга / О. Баттогтох /- д үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавь ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБЯЯР

461190007



114

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 9/02

Урт

Хөрөнгө хувьчлах санал уламжлах
тухай

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "б" дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-ийн 3 дахь хэсгийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. "Шугшаа уул" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөд бүртгэлтэй халуун усны барилга, халуун усны барилгын доорх газар, Эрүүл мэндийн төвийн хөрөнгөд бүртгэлтэй орон сууцыг хувьчлах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд уламжилсугай.

2. Хувьчилж, худалдан авах хүсэлтэй иргэдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Материалыг бүрдүүлж холбогдох байгууллагад хүргүүлэхийг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

461190002



115

Гурвантäs сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
2019 оны 10 сарын 21-ний өдрийн хурлын
9/2 тоот тогтоолын хавсралт

Хөрөнгө хувьчлах хүсэлт ирүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

№	Овог нэр	Регистрийн дугаар	Хувьчлах хөрөнгийн нэр	Хөрөнгийн одоо бүртгэлтэй байгаа байгууллагын нэр
1	Аюурын Занахүү	КГ56080417	Халуун усны барилга, халуун усны барилгын доорх газар	"Шугшаа-Уул" ОНӨААТҮГ
2	Нямаагийн Эрхэмбаяр	ХЖ67090401	Орон сууцны хорооллын 2-2 тоот орон сууц	Сумын Эрүүл мэндийн төв



116

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 9/04

Урт

Багийн хилийн заагийг тодорхойлж,
баталгаажуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2017 оны а/249 дүгээр тушаалаар батлагдсан "Баг хорооны хилийн заагийг тодорхойлох, баталгаажуулах аргачлал"-ыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын багуудын нутаг дэвсгэрийн хилийн заагийг хавсралтаар баталсугай.

2. Багийн хилийн заагийг тогтоосон шийдвэрийг холбогдох материалын хамт холбогдох газарт уламжилж, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 11 сарын 22-ны өдрийн 02 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б. ОТГОНБАЯР

461190058

117

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 10 сарын 21-ний өдрийн ~~Удт~~ тогтоолын хавсралт

БАГУУДЫН ХИЛИЙН ЗААГИЙН СОЛБИЦОЛ

№	Эргэлтийн цэгийн нэр	Солбицол	
		Уртраг	Өгрөгөр
ГОЁТ БАГ			
1	Өвөр дэвтээрийн худаг	735990.8339	4820972.3727
2	Халзан толгой	725054.5972	4812399.1446
3	Агуйтын сайр	708096.2538	4010873.5687
4	Тасархай	703407.6700	4809217.3100
5	Сономын худаг	690836.5200	4801850.6700
6	Гүдгэрийн тал	679026.0967	4801311.3038
7	Овоот толгой	671457.1539	4804643.7174
8	Зангатын тал	664492.9957	4804561.1016
9	Талын хайрхан	596301.4800	4817152.4400
10	Цагаан дэрс	537609.3491	4833879.6316
БАЯСАХ БАГ			
1	Өвөр дэвтээрийн худаг	735990.8339	4820972.3727
2	Халзан толгой	725054.5972	4812399.1446
3	Агуйтын сайр	708096.2538	4010873.5687
4	Тасархай	703407.6700	4809217.3100
5	Сономын худаг	690836.5200	4801850.6700
6	Гүдгэрийн тал	679026.0967	4801311.3038
7	Хөгшөө уул	680300.5476	4789802.9838
8	Баян-Өндөр уул	686591.9263	4789802.9838
9	Шивээгийн булаг	699771.3102	4759868.7044
10	1121.6	692848.1578	4725176.6901
11	Улсын 219-р багана	692599.5642	4715904.4036
ТОСТ БАГ			
1	Цагаан дэрс	537609.3491	4833879.6316
2	Талын хайрхан	596301.4800	4817152.4400
3	Зангатын тал	664492.9957	4804561.1016
4	Хүрэн босгын ам	662772.1345	4795171.6953
5	Муу ус	661980.3400	4787652.3200
6	Таван овоотын уул	656537.3838	4785220.2087
7	Дондогийн хяр	656110.2092	4782460.1954
8	Хөх овоот толгой	656021.6849	4777624.2135
9	Алаг толгой	654454.5006	4773840.8257
10	1549,6	651557.6240	4763526.8214
11	Хүрэн дэл толгой	651288.0806	4760286.5340
12	1239,8	647536.6711	4742866.4339
13	Улсын хил 214-215 дугаар баганын хооронд	646073.3440	4726210.2341
УРТ БАГ			
1	Эхэнэ майдар	671353.0300	4785582.4900
2	Товонгийн шанд	669800.8400	4784169.8900
3	Цохионо ус	664954.2400	4786115.6000
4	Муу ус	661980.3400	4787652.3200
5	Хүрэн босгын ам	662772.1345	4795171.6953
6	Зангатын тал	664492.9957	4804561.1015
7	Овоот толгой	671457.1539	4804643.7174

8	Гүдгэрийн тал	679026.0967	4801311.3038
9	Хөгшөө уул	680300.5476	4789802.9838
“БАГА ОВОО” БАГ			
1	Улсын хил 214-215 дугаар баганын хооронд	646073.3440	4726210.2341
2	1239,8	647536.6711	4742866.4339
3	Хүрэн дэл толгой	651288.0806	4760286.5340
4	1549,6	651557.6240	4763526.8214
5	Алаг толгой	654454.5006	4773840.8257
6	Хөх овоот толгой	656021.6849	4777624.2135
7	Дондогийн хяр	656110.2092	4782460.1954
8	Таван овоотын уул	656537.3838	4785220.2087
9	Муу ус	661980.3400	4787652.3200
10	Цохионо ус	664954.2400	4786115.6000
11	Товонгийн шанд	669800.8400	4784169.8900
12	Эхэнэ майдар	671353.0300	4785582.4900
13	Хөгшөө уул	680300.5476	4789802.9838
14	Баян-Өндөр уул	686591.9263	4789802.9838
15	Шивээгийн булаг	699771.3102	4759868.7044
16	1121,6	692848.1578	4725176.6901
17	Улсын 219-р багана	692599.5642	4715904.4036



120

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 9/65

Урт

Газрын үнэлгээний бүсчлэл,
газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн
тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсгийн "д" заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Гурвантэс сумын нутаг дэвсгэрийн төрийн өмчийн газрыг эзэмшүүлж, ашиглуулсны төлбөрийн хэмжээг тогтооход хэрэглэх илтгэлцүүрийн тоон утга, 1м.кв газрын жилийн төлбөрийн хэмжээг газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын код, газар ашиглалтын зориулалтыг нэгдүгээр, газрын үнэлгээний бүсийн зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Газрын үнэлгээ, бүсчлэл, төлбөрийн талаар гарсан тогтоол, шийдвэр, журмыг олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

3. Энэхүү шийдвэр гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 10 сарын 18-ны өдрийн 04 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР


461190053

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН СУУРЬ ҮНЭ, ИТГЭЛЦҮҮР, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Үндсэн ангилал	Код /Lcode1/	Ангиллын түвшин 1	Код /Lcode2/	Ангиллын түвшин 2 /ашиглалтын зориулалт/	Код /Lcode3/	Суурь үнэ /төгрөг/	Итгэлцүүр	Газрын төлбөрийн хэмжээ			
								Га /төгрөг/	М.кв /төгрөг/		
Хот, тосгон, бусад суурин газар	2	ХАА-н барилга, байгууламжийн газар	16	өвөлжөө, хаваржаа	1601	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				мал эмнэлгийн үйлчилгээний цэг	1602	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				үтрэм	1603	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				ХАА-н машин, механизмын хашаа, гараж	1604	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				тэжээл, бордооны агуулах	1605	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	1606	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				хүлэмж, дарлага	1607	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				тариалангийн талбай хоорондын зурвас газар	1608	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас	1609	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				бэлчээр дэх уст цэг	1610	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				зоорь	1611	12,000,000.00	0.50	30,000.00	3.00		
				21	Барилга, байгууламжийн газар	төрийн захиргааны байгууллага	2101	20,000,000.00	1.00	200,000.00	20.00
						шинжлэх ухааны байгууллага	2102	20,000,000.00	1.00	200,000.00	20.00
						урлаг, соёлын байгууллага	2103	20,000,000.00	1.00	200,000.00	20.00
						боловсролын байгууллага	2104	20,000,000.00	1.00	200,000.00	20.00
						эрүүл мэндийн байгууллага	2105	20,000,000.00	1.00	200,000.00	20.00
	банк, санхүүгийн байгууллага	2106	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	биеийн тамир, спортын байгууллага	2107	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	нам, олон нийтийн байгууллага	2108	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	сүм, хийд, шашны байгууллага	2109	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	зочид буудлын цогцолбор	2110	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	2111	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	дэд бүтцийн байгууллага	2112	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	музей, түүх, соёлын дурсгалт газар	2113	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	гадаадын шашны байгууллагын газар	2114	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	автомашин засвар үйлчилгээний цэг	2115	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	автомашин гараж	2116	20,000,000.00			1.00	200,000.00	20.00			
	22	Суурьшлын газар	9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	2201	20,000,000.00	1.00	200,000.00	20.00			
			5-8 давхар нийтийн орон сууц	2202	20,000,000.00	1.00	200,000.00	20.00			
			4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	2203	20,000,000.00	1.00	200,000.00	20.00			
			амины орон сууц	2204	14,000,000.00	1.00	140,000.00	14.00			
			гэр, орон сууцны хашааны газар	2205	14,000,000.00	1.00	140,000.00	14.00			
гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар			2206	14,000,000.00	1.00	140,000.00	14.00				
23			Үйлдвэрийн газар	үйлдвэрийн албан контор	2301	16,000,000.00	1.00	160,000.00	16.00		
				үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	2302	16,000,000.00	1.00	160,000.00	16.00		
				иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалтын газар	2401	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
				нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбай	2402	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
				цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбай	2403	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		

	Нийтийн эдэлбэрийн газар	24	нэрэмжит талбай, хөшөө, дурсгалын газар	2404	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			тоглоомын талбай	2405	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			эзэмшил, ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	2406	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			хөгийн цэг	2407	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			оршуулгын газар	2408	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			нийтийн эзэмшлийн бусад газар	2409	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			морин уралдааны бариа, автоспортын уралдааны газар	2410	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			нурсан барилга, балгас	2411	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			усан оргилуур	2412	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			Амралт, аялал жуулчлалын газар	25	хүүхдийн зуслан	2501	20,000,000.00	0.60	120,000.00	12.00
					амралтын газар	2502	20,000,000.00	0.60	120,000.00	12.00
					аялал, жуулчлалын бааз	2503	20,000,000.00	0.60	120,000.00	12.00
	рашаан, сувиллын газар	2504			20,000,000.00	0.60	120,000.00	12.00		
	Уурхайн газар	26	ашиглалт, олборлолт явуулж буй талбай	2601	50,000,000.00	0.30	300,000.00	30.00		
			уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	2602	16,000,000.00	1.00	160,000.00	16.00		
			нөөц газар	2604	16,000,000.00	0.10	32,000.00	3.20		
			нисэх, буух зурвас	3301	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
	Агаарын тээврийн газар	33	хамгаалалтын зурвас	3302	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			агаарын тээврийн барилга, байгууламж, төхөөрөмжийн талбай	3303	20,000,000.00	0.20	40,000.00	4.00		
			Дархан цаазат газар	6101	-	-	-	-		
	Улсын тусгай хэрэгцээний газар	Улсын тусгай хамгаалалттай газар	61	Байгалийн цогцолборт газар	6102	16,000,000.00	0.30	144,000.00	14.40	
				Байгалийн нөөцийн газар	6103	-	-	-	-	
				Дурсгалт газар	6104	-	-	-	-	
				Улсын хилийн зурвас газар	62	6201	-	-	-	-
Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар		63	6301	20,000,000.00	1.00	200,000.00	20.00			
Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар		64	6401	20,000,000.00	1.00	200,000.00	20.00			
Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай		65	6501	20,000,000.00	0.20	40,000.00	4.00			
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	68	6801	16,000,000.00	0.50	80,000.00	8.00				

122



Гуравтэс сумын газрын төлбөр,
үнэлгээний бүсийн зураг

Гурвантэс сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө

Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны
10 сарын 21-ний өдрийн 9-р тоот тогтоолын хавсралт

ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗРЫН АШИГЛАЛТ, ХАМГАЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Гурвантэс сумын хэмжээнд Хот тосгон, бусад суурины газрын ашиглалт хамгаалалтын төлөвлөлтөөр 11 байршилд 11,5 га газрыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад, ашиглуулж, эзэмшүүлэхээр төлөвлөв.

Барилга, байгууламжийн дэвсгэр газрын төлөвлөлт

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, хөрөнгө оруулалт

№	Багийн нэр	Байршил	Хэдэн нэгж талбарт	Газрын хэмжээ /га/	Зориулалт	Техникийн нөхцөл	Хэрэгжүүлэх хугацаа				Хөрөнгийн оруулалтын хэмжээ	Хариуцах эзэн
							I	II	III	IV		
1	Бага-Овоо баг,	Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд	10	10,5 га	ШТС, ажилчдын байр, Үйлдвэр үйлчилгээ, Хог булшлах	Зам харилцаа, гэрэл цахилгаанд ойрхон.				+		Сумын Засаг дарга, ГХБХБ хариуцсан мэргэжилтэн
2	Гоёт баг	Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд	1	1 га	Аялал жуулчлалын цогцолбор	Байгалийн үзэсгэлэнт газар				+		Сумын Засаг дарга, ГХБХБ хариуцсан мэргэжилтэн
4	Нийт		11	11,5га						+		



124

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 9/06

Урт

Сумын 2019 оны газар зохион
байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж хавсралтаар баталсугай.

2. Тогтоолыг аймгийн газрын албанд уламжилж, сумын хэмжээнд газар ашиглалт, эзэмшил, өмчлөлийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж олгохыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б. ОТГОНБАЯР

461190910

Гурвантэс сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө

2. Ашигт малтмал олборлож байгаа уурхайн дэвсгэр газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлт

Сумын хэмжээнд 2 байршилд 1,09 га газрыг Ашигт малтмал олборлох зориулалтаар үйл ажиллагаа явуулах, аж ахуй нэгж, байгууллагад эзэмшүүлж, ашиглуулахаар төлөвлөв.

Ашигт малтмал олборлох зориулалтаар үйл ажиллагаа явуулах иргэн,

аж ахуй нэгж, байгууллагад эзэмшүүлэх газрын төлөвлөлт

№	Багийн нэр	Байршил	Лицэнз эзэмшигчид	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй	Ашиглалтын Лагийн талбай	Талбайн солигдол	Газрын талбарын хэмжээ /га /	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сараар /												Харууцах эзэн
								I			II			III			IV			
								1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Бага-Овоо	2 нэгж талбарт	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй		Лагийн талбай		1,09 га											Сумын Засаг дарга, ГХБХБ хариуцсан мэргэжилтэн		
3	Нийт	2																		

3.ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН АШИГЛАЛТ,

ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

Сумын хэмжээнд байршилд 10,92га цахилгааны шугам тавихаар төлөвлөв.

Суурьшлын бүсэд шинээр үүсэх зам, шугам,

сүлжээний доорх газрын төлөвлөлт

№	Багийн нэр	Шинэ хороолол үүсэх газрын байршил	Тавигдах шаардлагатай зам шугам сүлжээний төрөл /км/					Хэрэгжүүлэх хугацаа /улирал/	Хануцсан эзэн	
			Холбооны шугам	Авто зам, Үерийн далан /төрөл ба км/	Эрчим хүч /төрөл ба км/	Үс, дулаан дамжуулах хоолой /км/	I			II
1	Бага-Овоо	Нарийн сухайт			0,48 га					Газрын даамал, СЗД, аймгийн ГХБХБГ
2	Бага-Овоо	Нарийн сухайт			10,44			+		Газрын даамал, СЗД, аймгийн ГХБХБГ

**4. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫГ АШИГЛАХ ХАМГААЛАХ
АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

Сумын хэмжээнд 0,65 га газарт ойн зурвас байгуулахаар төлөвлөв.

Ойн сангийн газарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт

№	Мэргэжлийн байгуулага, Ойн нөхөрлөлийн нэр	Ойн сангийн газрыг ашиглах хамгаалах арга хэмжээнд хамрагдсан нийт талбай /га/		Үүнээс															
		Газрын нэр	Талбай, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг	Ойн мэргэжлийн байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх талбай, га	Ойн нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлж хамгаалуулах талбай, га			Ой мод бэлтгэх талбай	Шинээр байгуулах мод үржүүлгийн газрын талбай, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг	Шинээр байгуулах жимс жимсгэний талбай, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг	Шинээр байгуулах ойн зурвасын хэмжээ, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг				
1	Аж ахуй нэгж еерийн хөрөнгөөр	0,65 га	0,65 га	Хамгаалах арга хэмжээнд хамрагдсан нийт талбай /га/	Газрын нэр	Талбай, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг	Ойн мэргэжлийн байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх талбай, га	Ойн нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлж хамгаалуулах талбай, га	Газрын нэр	Талбай, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг	Ой мод бэлтгэх талбай	Шинээр байгуулах мод үржүүлгийн газрын талбай, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг	Шинээр байгуулах жимс жимсгэний талбай, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг	Шинээр байгуулах ойн зурвасын хэмжээ, га	Хөрөнгө оруулалтын хэмжээ, төг

228